

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Боловсролын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/41/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2026 он

Санхүүгийн аудитын газрын захирал,

тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: С.Нацагдорж

Утас: 260512 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Оюунтөгөлдөр

Утас: 261729 Цахим хаяг: oyuntuguldurg@audit.gov.mn

Аудитор: Э.Булганчимэг

Утас: 261729 Цахим хаяг: bulganchimege@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	14
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	15
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	15
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	16
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	18
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	18
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	20
3.5.1 Төсвийн төлөвлөлт	20
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	21
3.5.3 Нэмэлт төсөв.....	22
3.5.4. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл	23
4. АУДИТЫН ТАЙЛАН	24
4.1 Ерөнхий зүйл	24
4.2 Материаллаг байдал.....	24
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	25
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	25
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	25
4.4.2 Бусад хууль, тогтоомжийн хүрээнд	26
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	27
4.5.1 Завсрын аудитын талаар	27
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	28
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	28
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	30
5.1 Албан шаардлага.....	30
5.2 Зөвлөмж	31
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	35

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БЕГ	Боловсролын ерөнхий газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА Т.НЯМ-ОЧИР ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/349

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсролын ерөнхий газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 414,052.2 мянган төгрөгийн зөрчил илэрч бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Байгууллагад төлөх 272,004.1 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;
- Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогоор биетээр байхгүй 6,944.1 мянган төгрөгийн хөрөнгийг дутаасан ажилтнаар нөхөн төлүүлээгүй зэрэг нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 16.5.1, 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 18 дугаар зүйлийн 18.1, 20.2.5, 20.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.5 дахь заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн цахим контент, дижитал сурах бичгийн цахим систем нэвтрүүлэх хөтөлбөрийн хүрээнд 6-12 дугаар ангийн дижитал, интерактив сурах бичгийн системийг 8,169,000.0 мянган төгрөгөөр гүйцэтгүүлж байгаа боловч тус системийг санхүүгийн тайланд бүртгэх, ашиглалт, хадгалалт, хэрэгжилтэд хяналт тавихтай холбоотой зохицуулалт байхгүй, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нарийвчлан тусгаагүй байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд нийт 4,393,145.3 мянган төгрөгийн номын түрээсийн орлого төвлөрснийг аккруэл сууриар бус мөнгөн сууриар бүртгэж байгаа нь харьяа байгууллагуудын номын түрээсийн орлого бүрэн төвлөрөхгүй, өглөг, авлага үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх, мөн өмч хөрөнгөнд тавих дотоод хяналт алдагдах эрсдэлтэй байна.

Бусад асуудлын хэсэг

Тус газар нь Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-т заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад асуудлын хэсгийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны Код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	154,205,714.35	242,550,139.68
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	5,851.00	5,851.00
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	5,851.00	5,851.00
31210	Төгрөг	5,851.00	5,851.00
31213	Арилжааны банк дахь харилцах	5,851.00	5,851.00
33	АВЛАГА	136,004,487.35	236,139,408.68
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	12,791,375.60	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	123,213,111.75	236,139,408.68
35	БАРАА МАТЕРИАЛ	18,195,376.00	6,404,880.00
35400	Хангамжийн материал	18,195,376.00	6,404,880.00
35410	Бичиг хэргийн материал	17,067,876.00	5,623,880.00
35420	Аж ахуйн материал	346,500.00	-
35470	Бусад хангамжийн материал	781,000.00	781,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,570,890,765.26	6,107,049,691.16
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,570,890,765.26	6,107,049,691.16
39200	Биет хөрөнгө	6,390,641,320.26	5,988,517,686.16
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,195,347,418.00	6,195,347,418.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(571,878,223.20)	(667,191,260.40)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	32,000,000.00	107,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(2,666,666.68)	(24,916,666.76)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	1,419,379,962.50	1,188,003,726.07
39206	Хуримтлагдсан элэгдэл	(884,970,916.38)	(892,304,489.14)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	343,327,131.88	151,715,488.97
39208	Хуримтлагдсан элэгдэл	(140,095,375.86)	(69,136,530.58)
39217	Ном	197,990.00	-
39300	Биет бус хөрөнгө	180,249,445.00	118,532,005.00
39301	Программ хангамж	310,499,320.00	308,249,320.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(130,249,875.00)	(189,717,315.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	6,725,096,479.61	6,349,599,830.84
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	311,897,006.41
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	311,897,006.41
41300	Өглөг	-	311,897,006.41
41360	Бусад өглөг	-	311,897,006.41
41361	Байгууллагад төлөх өглөг	-	311,897,006.41
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,725,096,479.61	6,037,702,824.43
51	Засгийн газрын хувь оролцоо	6,725,096,479.61	6,037,702,824.43
51100	Засгийн газрын оруулсан капитал	6,767,278,705.68	6,767,278,705.68
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	6,767,278,705.68	6,767,278,705.68
51200	Хуримтлагдсан үр дүн	(1,007,149,241.57)	(1,694,542,896.75)
51210	Өмнөх үеийн үр дүн	(703,105,040.97)	(1,007,149,241.57)
51220	Тайлант үеийн үр дүн	(304,044,200.6)	(687,393,655.18)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	964,967,015.50	964,967,015.50
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	6,725,096,479.61	6,349,599,830.84

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны Код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	32,708,620,415.83	22,068,723,393.22
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,816,160,109.35	22,068,723,393.22
120	Нийтлэг татварын бус орлого	3,816,160,109.35	3,341,417,385.82
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,477,905,757.35	3,080,521,685.98
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,477,905,757.35	3,080,521,685.98
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	330,414,352.00	258,602,164.84
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	7,840,000.00	2,293,535.00
122	Тусламжийн орлого	-	18,727,306,007.40
1221	Хандив тусламж /дотоод/	-	18,727,306,007.40
12211	Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	18,095,508,900.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	18,095,508,900.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	631,797,107.40
122131	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	509,895,037.40
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	121,902,070.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	28,892,460,306.48	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	26,859,389,600.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	26,859,389,600.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,033,070,706.48	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	736,613,726.88	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	719,708,419.60	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	576,748,560.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	33,012,664,616.43	22,585,129,669.41
21	УРСГАЛ ЗАРДАЛ	33,012,664,616.43	22,585,129,669.41
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	30,583,914,190.63	20,656,327,589.18
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,957,563,742.87	4,927,056,142.54
210101	Үндсэн цалин	2,835,240,853.66	2,738,396,581.46
210102	Нэмэгдэл	995,457,956.15	1,086,048,971.83
210103	Унаа хоолны хөнгөлөлт	594,265,416.16	703,907,293.88
210104	Урамшуулал	532,599,516.90	398,703,295.37
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	617,968,122.17	636,610,917.27
210201	Тэтгэврийн даатгал	445,942,222.17	428,982,197.58
210202	Тэтгэмжийн даатгал	43,006,500.00	51,907,229.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	21,503,200.00	27,982,506.57
210204	Ажилгүйдлийн даатгал	21,503,200.00	27,982,506.57
210205	Эрүүл мэндийн даатгал	86,013,000.00	99,756,476.62
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	181,970,378.22	219,183,279.75

Боловсролын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210301	Гэрэл, цахилгаан	129,647,524.50	154,922,319.42
210302	Түлш, халаалт	41,879,685.96	49,299,151.97
210303	Цэвэр, бохир ус	10,443,167.76	14,961,808.36
2104	Хангамж, бараа материалын зардал	289,453,127.27	151,235,161.51
210401	Бичиг хэрэг	196,956,242.44	88,175,845.01
210402	Тээвэр, шатахуун	61,406,850.00	37,920,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	19,614,527.83	13,614,470.50
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,475,507.00	11,523,946.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,137,900.00	9,919,060.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,500,000.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	17,637,900.00	-
210604	Урсгал засвар	-	9,919,060.00
2107	Томилолт, зочны зардал	377,058,200.00	107,156,000.00
210702	Дотоод албан томилолт	377,058,200.00	107,156,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,909,049,644.54	8,910,065,882.97
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,898,956,513.54	8,905,033,468.97
210803	Даатгалын үйлчилгээ	1,024,731.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	194,400.00	422,414.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,874,000.00	4,610,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,230,713,075.56	5,695,101,145.14
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,018,062,672.00	4,823,836,722.55
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	645,056,228.77	314,808,562.64
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	567,594,174.79	556,455,859.95
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,428,750,425.80	1,928,802,080.23
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,613,030,000.00	1,680,803,022.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,429,950,000.00	1,520,650,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	157,080,000.00	160,153,022.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	26,000,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	815,720,425.80	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	815,720,425.80	-
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	247,999,058.23
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	247,999,058.23
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(304,044,200.60)	(516,406,276.19)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	-	170,987,378.99
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	170,987,378.99
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	-	(170,987,378.99)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	(304,044,200.60)	(687,393,655.18)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны Код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	32,591,143,887.51	21,931,040,805.13
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,466,115,757.35	21,931,040,805.13
120	Нийтлэг татварын бус орлого	3,466,115,757.35	3,080,521,685.98
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,466,115,757.35	2,935,718,364.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,466,115,757.35	2,935,718,364.00
120009	Бусад орлого		144,803,321.98
122	Тусламжийн орлого	-	18,850,519,119.15
1221	Хандив тусламж /дотоод/		18,850,519,119.15
12211	Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	18,095,508,900.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	18,095,508,900.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	755,010,219.15
122131	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	557,233,537.40
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	197,776,681.75
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	29,125,028,130.16	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	26,859,389,600.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	26,859,389,600.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,265,638,530.16	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	752,579,808.83	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	782,525,100.60	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	730,533,620.73	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	32,565,184,487.51	21,926,040,805.13
21	УРСГАЛ ЗАРДАЛ	32,565,184,487.51	21,926,040,805.13
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	30,013,220,949.96	19,761,099,316.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,942,054,100.84	4,914,264,766.94
210101	Үндсэн цалин	2,819,731,211.63	2,725,605,205.86
210102	Нэмэгдэл	995,457,956.15	1,086,048,971.83
210103	Унаа хоолны хөнгөлөлт	594,265,416.16	703,907,293.88
210104	Урамшуулал	532,599,516.90	398,703,295.37
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	617,968,122.17	636,610,917.27
210201	Тэтгэврийн даатгал	445,942,222.17	428,982,197.58
210202	Тэтгэмжийн даатгал	43,006,500.00	51,907,229.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	21,503,200.00	27,982,506.57
210204	Ажилгүйдлийн даатгал	21,503,200.00	27,982,506.57
210205	Эрүүл мэндийн даатгал	86,013,000.00	99,756,476.62
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	181,970,378.22	219,183,279.75

Боловсролын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210301	Гэрэл, цахилгаан	129,647,524.50	154,922,319.42
210302	Түлш, халаалт	41,879,685.96	49,299,151.97
210303	Цэвэр, бохир ус	10,443,167.76	14,961,808.36
2104	Хангамж, бараа материалын зардал	130,814,600.77	78,972,486.50
210401	Бичиг хэрэг	83,104,912.94	46,624,200.00
210402	Тээвэр, шатахуун	21,381,850.00	4,056,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	19,614,527.83	12,676,432.50
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,713,310.00	15,614,954.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,934,030.00	9,919,060.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,363,500.00	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,394,630.00	-
210604	Урсгал засвар	21,175,900.00	9,919,060.00
2107	Томилолт, зочны зардал	379,533,200.00	107,156,000.00
210702	Дотоод албан томилолт	379,533,200.00	107,156,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,051,550,228.19	8,648,524,914.56
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,041,457,097.19	8,643,242,500.56
210803	Даатгалын үйлчилгээ	1,024,731.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	194,400.00	422,414.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,874,000.00	4,860,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,682,396,289.77	5,146,467,891.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,014,510,000.00	4,819,099,214.55
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	667,886,289.77	327,368,676.65
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,551,963,537.55	2,164,941,488.91
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	484,138,466.91
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	484,138,466.91
213112	Төсвийн байгууллагаас харьяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	484,138,466.91
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	245,934,864.23
2131123	Нэмэлт санхүүжилтийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлгийн зардал	-	100.00
2131124	Өөрийн орлогод тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	2,064,094.00
2131126	Нэмэлт санхүүжилтийн дансны авлагад тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	91,336,186.70
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	144,803,221.98
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,613,030,000.00	1,680,803,022.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,429,950,000.00	1,520,650,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	157,080,000.00	160,153,022.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	26,000,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	938,933,537.55	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	815,720,425.80	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	123,213,111.75	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	25,959,400.00	5,000,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (V)	25,959,400.00	5,000,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	25,959,400.00	5,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	25,959,400.00	5,000,000.00

Боловсролын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	25,959,400.00	5,000,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(25,959,400.00)	(5,000,000.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,851.00	5,851.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,851.00	5,851.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны Код	Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,767,278,705.68	964,967,015.50	(703,105,040.97)	7,029,140,680.21
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,767,278,705.68	964,967,015.50	(703,105,040.97)	7,029,140,680.21
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(304,044,200.60)	(304,044,200.60)
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,767,278,705.68	964,967,015.50	(1,007,149,241.57)	6,725,096,479.61
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,767,278,705.68	964,967,015.50	(1,007,149,241.57)	6,725,096,479.61
19	Тайлант үеийн үр дүн			(687,393,655.18)	(687,393,655.18)
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,767,278,705.68	964,967,015.50	(1,694,542,896.75)	6,037,702,824.43

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Данс-ны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	27,417,555,600.00	20,783,228,305.77	6,634,327,294.23	75.8
12	Татварын бус орлого	27,417,555,600.00	20,783,228,305.77	6,634,327,294.23	75.8
120	Нийтлэг татварын бус орлого	4,000,000,000.00	2,935,718,364.00	1,064,281,636.00	73.4
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	4,000,000,000.00	2,935,718,364.00	1,064,281,636.00	73.4
122	Тусламжийн орлого	23,417,555,600.00	17,847,509,941.77	5,570,045,658.23	76.2
122005	Төсвөөс санхүүжих	23,417,555,600.00	17,847,509,941.77	5,570,045,658.23	76.2
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	27,417,555,600.00	20,783,228,305.77	6,634,327,294.23	75.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	27,417,555,600.00	20,783,228,305.77	6,634,327,294.23	75.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	25,671,340,000.00	19,102,425,283.77	6,568,914,716.23	74.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,878,238,300.00	4,724,801,628.41	153,436,671.59	96.9
210101	Үндсэн цалин	2,927,261,600.00	2,536,142,067.33	391,119,532.67	86.6
210102	Нэмэгдэл	1,250,350,100.00	1,086,048,971.83	164,301,128.17	86.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	439,432,700.00	703,907,293.88	(264,474,593.88)	160.2
210104	Урамшуулал	261,193,900.00	398,703,295.37	(137,509,395.37)	152.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	618,406,200.00	618,406,200.00	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	420,516,300.00	410,777,480.31	9,738,819.69	97.7
210202	Тэтгэмжийн даатгал	49,472,400.00	51,907,229.93	(2,434,829.93)	104.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	24,736,200.00	27,982,506.57	(3,246,306.57)	113.1
210204	Ажилгүйдлийн даатгал	24,736,200.00	27,982,506.57	(3,246,306.57)	113.1
210205	Эрүүл мэндийн даатгал	98,945,100.00	99,756,476.62	(811,376.62)	100.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	244,330,100.00	219,183,279.75	25,146,820.25	89.7
210301	Гэрэл, цахилгаан	180,338,900.00	154,922,319.42	25,416,580.58	85.9
210302	Түлш, халаалт	48,789,100.00	49,299,151.97	(510,051.97)	101.0
210303	Цэвэр, бохир ус	15,202,100.00	14,961,808.36	240,291.64	98.4
2104	Хангамж, бараа материалын зардал	93,504,600.00	66,617,486.50	26,887,113.50	71.2
210401	Бичиг хэрэг	24,950,400.00	34,269,200.00	(9,318,800.00)	137.3
210402	Тээвэр, шатахуун	4,056,900.00	4,056,900.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	36,828,400.00	12,676,432.50	24,151,967.50	34.4
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,791,800.00	-	1,791,800.00	0.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	25,877,100.00	15,614,954.00	10,262,146.00	60.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,612,400.00	9,919,060.00	8,693,340.00	53.3
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,151,400.00	-	2,151,400.00	0.0
210604	Урсгал засвар	16,461,000.00	9,919,060.00	6,541,940.00	60.3
2107	Томилолт, зочны зардал	5,856,000.00	5,856,000.00	-	100.0
210702	Дотоод албан томилолт	5,856,000.00	5,856,000.00	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,481,973,000.00	8,601,186,414.56	4,880,786,585.44	63.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	13,454,548,100.00	8,595,904,000.56	4,858,644,099.44	63.9

**Боловсролын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

	үйлчилгээний төлбөр хураамж				
210803	Даатгалын үйлчилгээ	4,479,400.00	-	4,479,400.00	0.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	449,900.00	422,414.00	27,486.00	93.9
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	89,600.00	-	89,600.00	0.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	22,406,000.00	4,860,000.00	17,546,000.00	21.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,330,419,400.00	4,856,455,214.55	1,473,964,185.45	76.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,280,623,200.00	4,819,099,214.55	1,461,523,985.45	76.7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	49,796,200.00	37,356,000.00	12,440,200.00	75.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,746,215,600.00	1,680,803,022.00	65,412,578.00	96.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,746,215,600.00	1,680,803,022.00	65,412,578.00	96.3
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,585,508,100.00	1,520,650,000.00	64,858,100.00	95.9
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	160,707,500.00	160,153,022.00	554,478.00	99.7
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	5,851.00	(5,851.00)	100.0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	5,851.00	(5,851.00)	100.0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	0.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	0.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	171	123	48	71.9
620001	Удирдах ажилтан	17	15	2	88.2
620002	Гүйцэтгэх ажилтан	154	108	46	70.1
620003	Үйлчлэх ажилтан	-	-	-	0.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	-	755,010,219.15
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	755,010,219.15
122	Тусламжийн орлого	-	755,010,219.15
1221	Хандив тусламж /дотоод/	-	755,010,219.15
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	755,010,219.15
350011	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	557,233,537.40
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	197,776,681.75
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	663,674,032.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	663,674,032.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	663,674,032.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	189,463,138.53
210101	Үндсэн цалин	-	189,463,138.53
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	18,204,717.27
210201	Тэтгэврийн даатгал	-	18,204,717.27
2104	Хангамж, бараа материалын зардал	-	12,355,000.00
210401	Бичиг хэрэг	-	12,355,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	5,000,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	5,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	101,300,000.00
210702	Дотоод албан томилолт	-	101,300,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	47,338,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	47,338,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	290,012,676.65
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	290,012,676.65
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	91,336,186.70
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	-91,336,186.70
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	-91,336,186.70

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Боловсролын ерөнхий газар нь бүх шатны сургалтын байгууллагын суралцагчийн хөгжлийн бодлого, хууль тогтоомж болон арга хэмжээг хэрэгжүүлэх, бүх түвшний сургалт, хөтөлбөр, үнэлгээ, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүний бодлого болон арга хэмжээг хэрэгжүүлэх, бүх түвшний сургалтын, мэргэжлийн байгууллага болон боловсролын асуудал эрхэлсэн нутгийн захиргааны байгууллагын болон хүний нөөцийн чадавхыг сайжруулах, удирдлагыг хангах, иргэдийн насан туршийн хөгжил, суралцахуйн бодлого болон арга хэмжээг хэрэгжүүлэх, цахим боловсролын бодлого болон арга хэмжээний хэрэгжилтийг хангах, салбарын статистик бүртгэлийг хийх, төрийн захиргааны байгууллагын болон салбарын удирдах албан тушаалтны хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийг удирдлагаар хангах, боловсролын салбарын санхүү, төсвийн хэрэгжилт, хуваарилалт, гүйцэтгэлийг хэрэгжүүлэх, боловсролын салбарын хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг хэрэгжүүлэх, боловсролын салбарт хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний хэрэгжилтийг хангах, дотоод аудитыг зохион байгуулах зэрэг чиглэлийг тэргүүлэх чиглэлээ болгон үйл ажиллагаагаа явуулж байна.

Боловсролын ерөнхий газар нь эрхэм зорилгоо хөгжлийн чиг хандлага, нийгэм, соёлын үнэт зүйл, хэрэгцээнд нийцүүлэн боловсролын салбарын бодлого, арга хэмжээ, төлөвлөгөөний хэрэгжилтийг үндэсний түвшинд удирдлага зохион байгуулалтаар хангаж, төрт ёс, түүх, соёл уламжлал, үнэт зүйлсийг өвлөсөн, ардчилсан, хүмүүнлэг, ёс зүйг дээдлэн сахисан, дэлхийд өрсөлдөхүйц мэдлэг чадвартай, нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулдаг, эрүүл, хариуцлагатай, төлөвшсөн иргэнийг бэлтгэхэд оршино гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

- Бүх түвшний суралцагчийн эрх, хөгжил, хамгаалал, жендерийн эрх тэгш байдал, тэгш хамруулах боловсрол, хоол үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбоотой эрх бүхий байгууллагаас баталсан хууль тогтоомж, шийдвэр, арга хэмжээ, төлөвлөгөөнд хэрэглэгчдийн удирдлага зохион байгуулалтаар хангах;
- Бүх шатны боловсролын сургалтын хөтөлбөр, үнэлгээ, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнтэй холбоотой эрх бүхий байгууллагаас баталсан хууль тогтоомж, шийдвэр, арга хэмжээ, төлөвлөгөөнд хэрэглэгчдийн удирдлага зохион байгуулалтаар хангах, таамаглал онолыг нэвтрүүлэх;
- Бүх түвшний сургалтын болон мэргэжлийн байгууллагын хүний нөөцийн хөгжил, удирдлагатай холбогдох эрх бүхий байгууллагаас баталсан хууль тогтоомж, шийдвэр, арга хэмжээ, төлөвлөгөөнд хэрэглэгчдийн удирдлага зохион байгуулалтаар хангах, хүний нөөцийн жендерийн эрх тэгш байдлыг хангаж ажиллах;
- Боловсролын цахим шилжилтийн бодлого, арга хэмжээний хэрэгжилтийг дэмжихэд чиглэсэн судалгааны ажлыг гүйцэтгэх, зөвлөмж гаргах, мэдээллийн сан бүрдүүлэх, цахим шилжилтийн бодлого боловсруулахад оролцох;
- Салбарын болон салбар хоорондын бодлого, хөтөлбөрийг уялдуулан хэрэгжүүлэхэд шаардлагатай судалгааны ажлыг гүйцэтгэх, зөвлөмж гаргах,

мэдээллийн сан бүрдүүлэх, салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх;

- Төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн болон салбарын бусад талуудтай хамтран ажиллах замаар хүүхэд, залуучууд, эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан мэдлэг олгох сургалт, сурталчилгааны үйл ажиллагаа явуулах;
- Багш, сурган хүмүүжүүлэгчид болон салбарын бусад ажилтныг чадавхжуулах, мэргэжил дээшлүүлэх, хөгжлийг дэмжихэд чиглэсэн судалгааны ажлыг гүйцэтгэх, зөвлөмж гаргах, мэдээллийн сан бүрдүүлэх, багшийг тасралтгүй хөгжих нөхцөл боломжоор хангаж ажиллах, Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломжийг олгох;
- Боловсролын салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитыг хэрэгжүүлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, тандалт, судалгаа хийх, үр дүнг төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох талуудад тайлагнах.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Боловсролын ерөнхий газар нь Монгол Улсын Үндсэн Хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Багш хөгжлийг дэмжих тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжид нийцүүлэн чиг үүргээ хэрэгжүүлж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.5 дах хэсэгт 2025 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт орсон;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд 2025 оны 5 сарын 30 өдөр нэмэлт өөрчлөлт орсон;
- Засгийн газрын 2025 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 215 дугаар тогтоолоор Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх, зээлийг эргэн төлүүлэх журам шинэчлэн батлагдсан;
- Засгийн газрын 2025 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч зарим агентлагийн орон тооны дээд хязгаарыг 91 байхаар шинэчлэн батлагдсан;
- Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 214 дүгээр тогтоолоор Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам батлагдаж, 2025 оноос даган мөрдөж байна;

- Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 224 дугаар тогтоолоор Төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай шинэчлэн батлагдсан;
- Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 225 дугаар тогтоолоор Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулсан;
- Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 226 дугаар тогтоолоор Төрийн жинхэнэ албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоосон;
- Засгийн газрын 2025 оны 4 дугаар сарын 02-ны өдрийн 158 дугаар тогтоолоор 2026 оныг "боловсролыг дэмжих жил" болгон зарласан.
- Боловсролын сайдын 2025 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн А/465 дугаар тушаалаар Боловсролын цахим мэдээллийн сан бүрдүүлэх, ажиллуулах журам шинэчлэн батлагдсан;
- Боловсролын сайдын 2025 оны 8 дугаар сарын 01-ний өдрийн А/405 дугаар тушаалаар Төрийн болон орон нутгийн өмчийн мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн сургалтын менежерийн албан тушаалд тавих нийтлэг шаардлага, мэргэжлийн багшийн албан тушаалд тавих нийтлэг шаардлага, ерөнхий эрдмийн багшийн албан тушаалд тавих нийтлэг шаардлага, ерөнхий эрдмийн сургалт хариуцсан арга зүйчийн албан тушаалд тавих нийтлэг шаардлага, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалт хариуцсан арга зүйчийн албан тушаалд тавих нийтлэг шаардлага, нийгмийн түншлэл, үйлдвэрлэлийн дадлага, сургалт хариуцсан арга зүйчийн албан тушаалд тавих нийтлэг шаардлага, багшийн хөгжил хариуцсан арга зүйчийн албан тушаалд тавих нийтлэг шаардлага, дотуур байрны багшийн албан тушаалд тавих нийтлэг шаардлага шинэчлэн батлагдсан;
- Боловсролын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн А/37 дугаар тушаалаар Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд өөрийн болон хөндлөнгийн үнэлгээ хийх журам шинэчлэн батлагдсан;
- Боловсролын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/20 дугаар тушаалаар Боловсролын салбарын төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоох тухай журам шинэчлэн батлагдсан;
- Боловсролын сайдын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А/613 дугаар тушаалаар Төрийн үйлчилгээний зарим албан хаагчийн цалингийн хэмжээг тогтоох тухай журам хүчингүй болсон;
- Боловсролын сайдын 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/87 дугаар тушаалаар Сурах бичгийн эх зохиох, санал авах, дүгнэлт гаргуулах үйл ажиллагааны журам батлагдсан;
- Боловсролын сайд, гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, сангийн сайдын хамтарсан 2025 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн А/136, А/80, А/69 дугаар тушаалаар Насан туршийн суралцахуйн төвийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт батлагдсан;

- Боловсролын сайд, гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2025 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн А/253, А/123 дугаар тушаал Иргэний албан бус боловсрол болон амьдралын орчинд суралцаж эзэмшсэн мэдлэг, чадварыг албан боловсролын тогтолцоонд хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах журам батлагдсан;
- Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, хууль зүй, дотоод хэргийн сайд, гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд нарын хамтарсан 2025 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн А/53, А/95, А/76 дугаар тушаалаар Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас Урьдчилан сэргийлэх, хамгаалах журам батлагдсан.

Боловсролын ерөнхий газрын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна. Тайлант онд дээд шатны төсөв захирагчийн хяналт, шинжилгээ, үнэлгээний газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт, шалгалт хийж ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглахгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас 2025 онд 8 арга хэмжээ хэрэгжүүлэхээр Дотоод аудитын төлөвлөгөө батлуулснаас тайлант онд нийт 128 байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт 92 болон төлөвлөгөөт бус 36 хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитыг гүйцэтгэж, зөвлөмж өгч, нийтлэг илэрч буй алдаа, дутагдлын талаар зөвлөн тусалж ажилласан байна. Төлөвлөгөөний биелэлт 90 хувьтай.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Боловсролын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус газар нь Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/22 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж ажилладаг бөгөөд уг баримт бичиг нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн боловч 2021 оноос хойш өөрчлөлт ороогүй, салбарын үйл ажиллагааны онцлогийг нарийвчлан тусгаагүй, ерөнхий байдлаар боловсруулсан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Боловсролын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайланг УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант онд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 375,496.7 мянган төгрөгөөр буюу 5.6 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	5.9	5.9	-
Авлага	136,004.5	236,139.4	100,134.9
Бараа материал	18,195.4	6,404.8	(11,790.6)
Үндсэн хөрөнгө	6,570,890.7	6,107,049.7	(463,841.0)
Нийт хөрөнгө	6,725,096.5	6,349,599.8	(375,496.7)
Өр төлбөр	-	311,897.0	311,897.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	6,725,096.5	6,037,702.8	(687,393.7)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,725,096.5	6,349,599.8	(375,496.7)

Дээрх хүснэгтээс харахад дансны үлдэгдэлд материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Авлага дансны үлдэгдэл 100,134.9 мянган төгрөгөөр буюу 73.6 хувиар өссөн нь өмнөх оны татаас, санхүүжилтийн авлага 123,213.1 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 12,791.4 мянган төгрөгийг тус тус барагдуулж, төрийн санд төвлөрүүлсэн Математикийн хичээлийн Эдүтэн цахим системийн төлбөрийн 144,803.3 мянган төгрөг, эдийн засгийн хүндрэлийн үеийн боловсролын чанар хүртээмж сайжруулах төслийн 48,100.4 мянган төгрөг, Тэгш боломжийг бүрдүүлэх замаар суралцахуйг дэмжих төсөл 31,487.1 мянган төгрөг, НҮБ-ын хүүхдийн сан 10,148.6 мянган төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн.
- Бараа материалын дансны үлдэгдэл 11,790.6 мянган төгрөгөөр буюу 64.8 хувиар буурсан нь тайлант онд зарцуулсан бичиг хэргийн материалтай холбоотой.
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 463,841.0 мянган төгрөгөөр буюу 7.1 хувиар буурсан нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 496 дугаар тогтоолын дагуу үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхөөгүй, ашиглалтын шаардлага хангахгүй болсон 71 нэрийн нийт 318,170.0 мянган төгрөгийн балансын үнэтэй 311,722.0 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг акталж, данснаас хассан, мөн 2025 оны 479 дүгээр тогтоолын дагуу 10 нэрийн 217,542.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлсэн, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 1/432, А1/2681 албан тоот зөвшөөрлийн дагуу 263,602.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэлд авсан, тайлант онд байгуулсан 556,455.9 мянган төгрөгийн элэгдлийн зардал зэрэг нь голлох нөлөөг үзүүлсэн.
- Өр төлбөрийн данс 311,897.0 мянган төгрөгөөр буюу 100.0 хувиар өссөн нь Интернетом ХХК-тай байгуулсан Ерөнхий боловсролын сургуульд 2025-2026

оны хичээлийн жилд VI-XII ангийн сурах бичиг тээвэрлэн хүргэх гэрээний үлдэгдэл 271,185.0 мянган төгрөг, Соёмбо принтинг ХХК-тай байгуулсан Ерөнхий боловсролын сургуульд 2025-2026 оны хичээлийн жилд IV ангийн сурах бичгийг хэвлэн нийлүүлэх гэрээний үлдэгдэл 24,959.9 мянган төгрөг, ШУТИС-ийн Хүнс, хөнгөн үйлдвэрлэл, дизайны сургуультай байгуулсан гэрээний үлдэгдэл төлбөр 9,300.0 мянган төгрөгийн үлдэгдэл төлбөрийг гүйцэтгэлээр олгосон, санхүүжилтийн эрх тавигдаагүй, санхүүжилт хүрэлцээгүй шалтгаанаар төлөгдөөгүй.

- Засгийн газрын хувь оролцоо данс 687,393.7 мянган төгрөгөөр буюу 10.2 хувиар буурсан нь тайлант оны үр дүнтэй холбоотой.
- Тус байгууллагын биет бус хөрөнгөнд 307,649.3 мянган төгрөгийн балансын үнэтэй хэрэглээний 1300 ширхэг Microsoft office 365 программ, 600.0 мянган төгрөгийн балансын үнэтэй санхүүгийн программ бүртгэлтэй -

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 53,764,482.7 мянган төгрөг, нийт зарлагыг 53,764,482.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид 2024 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн 01/3310 дугаартай албан бичгээр хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт зардлыг 35,668,973.8 мянган төгрөгөөр бууруулж, 18,095,508.9 мянган төгрөгөөр баталсан байна. Тухайлбал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж, бараа үйлчилгээний бусад зардлыг 31,725,191.5 мянган төгрөгөөр, цалин, хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 2,463,386.5 мянган төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 720,539.0 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 384,675.8 мянган төгрөгөөр, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 280,117.3 мянган төгрөгөөр, бусад зардлыг 159,921.8 мянган төгрөгөөр тус тус бууруулж, урсгал шилжүүлгийг 64,858.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Төсвийн төслийн саналыг 66.3 хувиар бууруулахад сурах бичгийн хөтөлбөр шинэчлэхтэй холбоотой сурах бичиг зохиох, хэвлэх 20,000,000.0 мянган төгрөг, боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх 4,321,200.0 мянган төгрөг, системийн ба өдөр тутмын сургалтын нийцлийг хангах, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, ЕБС-д олон улсын стандарт нэвтрүүлэх бэлтгэл арга хэмжээ 3,044,000.1 мянган төгрөгийг тус тус батлагдаагүйгээс шалтгаалсан байна.

Төсвийн төлөвлөлтийн тухайд төсөв захирагчийн саналыг харгалзан үзэлгүйгээр батлагдсан төсвийг бууруулсан, мөн батлагдсан төсвийн тодорхой хэсэгт Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар “Төсвийн сахилга бат хариуцлагыг чангатгах тухай” албан даалгавартай холбогдуулан санхүүжилтийн эрх нээгээгүй байна.

Тайлант оны баталсан төсвийг 5,322,046.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 23,417,555.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 4,000,000.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос, нийт 27,417,555.6 мянган төгрөгийг баталсан.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны гүйцэтгэлээр улсын төсвөөс 18,095,508.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 2,935,718.4 мянган төгрөг, Эдүтэн хөтөлбөрийн хүрээнд 144,803.3 мянган төгрөгийг тус тус бүрдүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 20,783,228.3 мянган төгрөг буюу 75.8 хувьтай байгаа нь зарим зардлын хуваарь 12 сард хуваарилагдсан, санхүүжилтийг төрийн сан жилийн эцсийн өдрүүдэд эрх нээж өгсөнтэй холбоотой байна. Улсын төсвийн санхүүжилтийн 247,999.0 мянган төгрөг, математикийн хичээлийн Эдүтэн цахим системийн төлбөрийн 144,803.3 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг тус тус улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн нийт зардлын 41.4 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд, 23.4 хувийг бараа үйлчилгээний бусад зардалд, 22.7 хувийг цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд, 8.1 хувийг урсгал шилжүүлэгт, үлдсэн 4.4 хувийг бусад зардалд тус тус зарцуулсан байна.

Төсвийг дутуу зарцуулсан арга хэмжээний хувьд цахим шилжилт 1,461,500.0 мянган төгрөгөөр, олимпиад зохион байгуулах 51,021.6 мянган төгрөгөөр, боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх 284,182.3 мянган төгрөгөөр, боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө 961,373.0 мянган төгрөгөөр, үндсэн үйл ажиллагаа 248,770.6 мянган төгрөгөөр, харуул, хамгаалалт 3,161.5 мянган төгрөгөөр, байр ашиглалт 825.6 мянган төгрөгөөр, ахмад дайчин, алдар цолтой 64,858.1 мянган төгрөгөөр, ажил олгогчоос олгох тэтгэмж 554.5 мянган төгрөгөөр, ЕБС-ийг сурах бичгээр хангах 2,491,734.3 мянган төгрөгөөр, сурах бичгийн түрээс 1,066,345.7 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

		/мянган төгрөгөөр/			
	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
71802	Ерөнхий боловсрол хөтөлбөр	9,240,131.6	6,482,054.7	2,758,076.9	70.2
80316	Цахим шилжилт арга хэмжээ	6,277,620.0	4,816,120.0	1,461,500.0	76.7
81804	Олимпиад зохион байгуулах	1,349,233.2	1,298,211.6	51,021.6	96.2
81823	Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	617,800.0	333,617.7	284,182.3	54.0
81834	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө	995,478.4	34,105.4	961,373.0	3.4
71808	Боловсрол, шинжлэх ухааны бодлого удирдлага	18,177,424.0	14,301,173.6	3,876,250.4	78.7
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	5,939,171.9	5,690,401.3	248,770.6	95.8
80219	Харуул, хамгаалалтын зардал	53,861.5	50,700.0	3,161.5	94.1
80226	Байр ашиглалтын үйлчилгээ	489,699.6	488,874.0	825.6	99.8
80704	Ахмад дайчин, алдар цолтой	1,585,508.1	1,520,650.0	64,858.1	95.9
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	160,707.5	160,153.0	554.5	99.7

Боловсролын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

81569	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	7,800.0	7,800.0	-	100.0
81817	ЕБС-ийг сурах бичгээр хангах	5,940,675.4	3,448,941.0	2,491,734.4	58.1
81848	Сурах бичгийн түрээс	4,000,000.0	2,933,654.3	1,066,345.7	73.3
Бүгд		27,417,555.6	20,783,228.3	6,634,327.3	75.8

Судалгааны үр дүн: Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу аудитын явцад тус байгууллагаас дараах зардлын судалгааг авч, үр дүнг дүгнэлээ. Тухайлбал:

- Тайлант онд орон тооны цомхотгол хийгдээгүй байна. Засгийн газрын 2025 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 14 дүгээр тэмдэглэлээр Боловсролын салбарын төрийн захиргааны бусад байгууллагын чиг үүрэгт шинжилгээ хийж, дүнг танилцуулах, Боловсролын яамны зарим харьяа байгууллагын чиг үүрэгт хийсэн иж бүрэн шинжилгээний үр дүнд үндэслэн чиг үүргийн дахин хуваарилалт хийх чиглэлээр холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах асуудлыг судалж танилцуулахыг Боловсролын сайдад даалгасан. Боловсролын ерөнхий газарт бүтцийн өөрчлөлт хийх болсонтой холбогдуулан 2025 онд шинээр ажилтан авах сонгон шалгаруулалтыг зогсоосон.
- Нэг хүнд ногдох 1 өдрийн хоолны зардал 25.0 мянган төгрөг, унааны зардал 1.0 мянган төгрөг байхаар Боловсролын ерөнхий газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар баталсан байна. Унаа, хоолны хөнгөлөлтийн зардлын төсөв 439,432.7 мянган төгрөгөөр батлагдаж, 703,907.3 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй байна.
- Гадаад томилолтын зардал батлагдаагүй.
- Боловсролын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2-т багш, ажилтны мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулж, мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлэх чиг үүргийн хүрээнд Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх арга хэмжээний хүрээнд 333,617.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.
- Тайлант онд хэвлэл, мэдээллийн байгууллагатай байгуулсан гэрээ байхгүй.
- Тайлант онд төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой гарсан зардал байхгүй.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус газар нь тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд хандив тусламжаар 557,233.5 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 197,776.7 мянган төгрөг, нийт 755,010.2 мянган төгрөгийг бүрдүүлж, үйл ажиллагаанд 663,674.0

мянган төгрөгийг зарцуулж, 91,336.2 мянган төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар тусган улсын төсөвт төвлөрүүлсэн.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл

Боловсролын ерөнхий газрын даргын баталсан 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 20,767,793.2 мянган төгрөгийн 18 төсөл, арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар, 3,627,000.0 мянган төгрөгийн 2 төсөл, арга хэмжээг нэг эх үүсвэрээр худалдан авах аргаар, 611,688.7 мянган төгрөгийн 3 төсөл, арга хэмжээг харьцуулалтын аргаар, нийт 25,006,481.9 мянган төгрөгийн 24 төсөл арга, хэмжээг тус тус хэрэгжүүлэхээр тусгажээ. Үүнээс 5 төсөл, арга хэмжээ нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар, 19 төсөл, арга хэмжээг урсгал төсвөөс санхүүжүүлэхээр тусгасан байна.

Урсгал төсвийн нийт 15,104,447.4 мянган төгрөгийн 19 төсөл, арга хэмжээнээс гүйцэтгэлээр 12,017,990.0 мянган төгрөг буюу худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт 53.1 хувьтай байна.

Тухайлбал, 8,390,990.0 мянган төгрөгийн 7 төсөл, арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар, 2,277,000.0 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээг нэг эх үүсвэрээр худалдан авах аргаар, 1,350,000.0 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээг шууд гэрээ байгуулах аргаар, нийт 12,017,990.0 мянган төгрөгийн 9 төсөл арга, хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, 18 гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, гүйцэтгэлийн дагуу санхүүжилтийг олгосон.

Тайлант онд 10 төсөл, арга хэмжээ төсөв татагдсан, гүйцэтгэгч шалгараагүй, амжилтгүй болсон шалтгаанаар худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Боловсролын ерөнхий газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Боловсролын ерөнхий газар, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах цахим контент, дижитал болон хэвлэмэл сурах бичгийн бүртгэл, номын түрээсийн орлогын бүртгэл, мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, өглөг, цалингийн тооцооллыг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Г.Оюунтөгөлдөр, аудитор Э.Булганчимэг нар гүйцэтгэж, аудитын үе шатны чанарын хяналтыг аудитын менежер С.Нацагдорж, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Боловсролын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01/187 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайланг, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 33,012,664.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 330,126.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тус байгууллагын 2025 оны нийт зардлын дүн өмнөх оноос 10,427,535.0 мянган төгрөгөөр буурсан нь материаллаг байдлыг сонгосон суурь үзүүлэлт буюу нийт зардалд материаллаг хэмжээний өөрчлөлт орсныг илтгэж байна. Аудитын явцад материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2025 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 22,756,117.1 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 227,561.2 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор төсвийн шууд захирагч төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах дараах арга хэмжээг авч ажилласан байна. Тухайлбал:

- Багаж хэрэгсэл, тавилга, зочин төлөөлөгч хүлээн авах зардал, гадаад томилолт, ажил олгогчоос олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардал, хог хаягдал зайлуулах, нормын хувцас худалдан авах зардал, ном хэвлэл, хөдөлмөр хамгааллын хэрэгсэл худалдан авах зардал батлагдаагүй.
- Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжүүлэх хүрээнд шаардлагагүйгээр их хэмжээгээр бараа, материал нөөцлөхгүй байх арга хэмжээг авч байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангаж ажилласан.
- Тайлант онд улсын төсвийн санхүүжилтээс зарцуулагдаагүй 247,999.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн.
- Боловсролын ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 3 тээврийн хэрэгслээс 2 нь бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаараар сольсон байна. Үлдсэн 1 тээврийн хэрэгслийг БЕГ-ын даргын 2026 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн "Нийслэлийн авто тээврийн хэрэгслийн бүртгэл хяналтын төв"-д "Дэвсгэр өнгө солиулах тухай" 01/325 дугаар албан тоотоор хандсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 2,550,620.0 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 2 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Зөвлөмж

Илрүүлэлт 1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих 27 нэр төрлийн 147 мэдээллээс 137 мэдээллийг хугацаанд нь, 2 нь хугацаа болоогүй, 8 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна. Нийтэд ил тод мэдээлэх шаардлагатай 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл гэсэн цонх нээгдээгүй, нээлгэх талаар асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх арга хэмжээ авч ажиллаагүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 “хариуцлагатай байх”, Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.3.7 “хөрөнгө оруулалтын зарлага, санхүүжилтийг төсөл, объект тус бүрээр;”, 6.4.4 “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг хуульд заасан хугацаанд бүрэн, үнэн зөв байршуулж, мэдээлэл хоцроох зөрчлийг давтан гаргахгүй байх, нийтэд ил тод мэдээлэх шаардлагатай цонхыг нээлгэх талаар асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх арга хэмжээ авч ажиллах зөвлөмж өгөв.

4.4.2 Бусад хууль, тогтоомжийн хүрээнд

Худалдан авах ажиллагаатай холбоотой

Албан шаардлага

Илрүүлэлт 2. Кембрижийн их сургуулийн канцлер, магистр, эрдмийн албанаас 1,350,000.0 мянган төгрөгийн үйлчилгээг нэг эх үүсвэрээр худалдан авахаар төлөвлөгөөнд тусгасан боловч шууд гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 “Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 “Захиалагч дараах нөхцөлд нэг эх үүсвэрээс худалдан авах аргыг хэрэглэж болно: 36.1.1 оюуны өмчийн эрхийг хамгаалах шаардлагаар бараа, ажил, үйлчилгээг үйлдвэрлэгч оюуны өмчийн эрх эзэмшигч, эсхүл түүнээс лицензийн гэрээний дагуу ашиглах эрх авсан албан ёсны нэг этгээд гүйцэтгэх боломжтой бол”, 41 дүгээр зүйлийн 41.1 “Худалдан авах гэрээ дараах нөхцөлийн аль нэгд хамаарах бол илт хууль бус байна: 41.1.1 энэ хуулийг зөрчиж гэрээ шууд байгуулсан”, Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/250 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.2 “Захиалагч төлөвлөгөөг батлагдсан нийт төсөвт үндэслэн төсөл, арга хэмжээ нэг бүрээр энэ журмын хавсралтын 1 дүгээр маягтын дагуу цахим системд боловсруулна” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан арга, хэлбэрээр худалдан авах ажиллагааг зохион байгуулахгүй байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 3. Тус байгууллага нь он дамжин хэрэгжиж буй 2,550,620.0 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй, шууд худалдан авалт хийсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу

зарцуулах”, 24 дүгээр зүйлийн 24.4 “Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 “захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална”, Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/250 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2 “захиалагч төлөвлөгөөг батлагдсан нийт төсөвт үндэслэн төсөл, арга хэмжээ нэг бүрээр энэ журмын хавсралтын 1 дүгээр маягтын дагуу цахим системд боловсруулна.” 3 “тухайн жилийн төсөвт он дамжин хэрэгжихээр тусгагдсан төсөл, арга хэмжээг төлөвлөгөөнд тусгаж, тайлбарт он дамжин хэрэгжиж байгаа талаар дурдана” гэж тус тус заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөл, арга хэмжээг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгалгүй, шууд худалдан авалт хийж байгаа зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

Тушаал, шийдвэртэй холбоотой

Зөвлөмж

Илрүүлэлт 4. Олимпиадын ерөнхий хорооны бүрэлдэхүүнийг баталсан тушаал гаргаагүй байна. Үүний улмаас олимпиад зохион байгуулах үйл ажиллагаа эрх зүйн үндэслэлгүй явагдах, хяналт, шийдвэр гаргалт алдагдах эрсдэлтэй байна.

Энэ нь Боловсролын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.5 “улсын олимпиад, мэргэжлийн болон техникийн боловсролын ур чадварын уралдаан зохион байгуулах журам, ерөнхий боловсролын сургуульд кабинет, лаборатори байгуулах, ашиглах журам баталж мөрдүүлэх”, Боловсролын ерөнхий газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн “Улсын олимпиад зохион байгуулах журам батлах тухай” журмын 2.2 “Ерөнхий хорооны бүрэлдэхүүнийг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дарга батална” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Олимпиадын ерөнхий хорооны бүрэлдэхүүнийг баталж, олимпиадын үйл ажиллагааг зохион байгуулах зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар Боловсролын ерөнхий газрын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулж, мөнгөн хөрөнгө, зардал, шилэн данс, түрээсийн номын орлого зэрэгт горим, сорил хэрэгжүүлж, аудитын илрүүлэлтийг шалгагдагч байгууллагад танилцуулсан.

Завсрын аудитаар нийт 478,679.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнд 307,649.3 мянган төгрөгийн 2 алдааг залруулах, 171,030.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах талаар 5 зөвлөмж өгснөөс 171,030.1 мянган төгрөгийн 2 зөвлөмж хэрэгжсэн байна.

Мөн байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт олж аван эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратеги боловсруулж, төлөвлөгөөг батлуулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн шийдвэрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2025 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 1/1095 дугаар албан бичгээр төрийн аудитын байгууллагад ирүүлсэн байна.

Боловсролын ерөнхий газрын 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн 1/3587 дугаар албан бичгээр аудитын шийдвэрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийн тайлан, нотлох баримтыг ирүүлсэн байна.

Өмнөх аудитаар нийт 6,926,346.3 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 6,490,418.4 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 435,927.9 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн байна. Өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт нотлох баримттай тулган шалгаж 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	4	6,490,418.4	4	6,490,418.4	100.0
Зөвлөмж	2	435,927.9	2	435,927.9	100.0
Нийт дүн	6	6,926,346.3	6	6,926,346.3	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитаар илэрсэн дараах асуудлуудад дээд шатны захирагч анхаарлаа хандуулах шаардлагатай байна. Тухайлбал:

- Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/22 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт 2021 оноос хойш өөрчлөлт ороогүй, салбарын үйл ажиллагааны онцлогийг нарийвчлан тусгаагүй.
- Засгийн газрын 2025 оны Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 52 дугаар тогтоолоор тус байгууллагын орон тоог 91 байхаар тогтоосон боловч 2021 оны Засгийн газрын 403 дугаар тогтоолыг баримталж 171 орон тоогоор төлөвлөж, гүйцэтгэлээр 123 орон тоотой ажилласан нь тайлант онд Боловсролын ерөнхий газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлаагүйтэй холбоотой.
- Тус байгууллагын эзэмшиж, ашиглаж буй барилга байгууламжийн газар буюу эзэмших эрхийн гэрчилгээ нь санхүүгийн тайланд бүртгэлгүй, эзэмших эрх нь

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам /хуучин нэрээр/-ны нэр дээр бүртгэлтэй.

- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, батлах, ил тод мэдээлэхтэй холбоотой асуудал;
- Төсвийн шууд захирагчийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын хавсралтад заасны дагуу бэлтгэхээр зохицуулсан боловч тус хавсралтад тусгагдсан санхүүгийн тайлан бэлтгэх маягтууд болон “Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн систем”-д шивж буй тайлангийн зарим үзүүлэлт хоорондоо зөрүүтэй байна. Иймд журмаар батлагдсан маягт болон нэгдсэн системийн тайлангийн үзүүлэлтийн зөрүүг арилгаж нэгдсэн ойлголтоор санхүүгийн тайлан бэлтгэсэн эсэх.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайлагналтай холбоотой нийт 414,052.2 мянган төгрөгийн 11 зөрчил¹ илэрсэнд, 278,948.2 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 135,104.1 мянган төгрөгийн зөрчилд 9 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 414,052.2 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшин 227,561.2 мянган төгрөгөөс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

1. Авлага, өглөгийн данстай холбоотой

Илрүүлэлт 1. Байгууллагад төлөх 272,004.1 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагад төлөх өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой

Илрүүлэлт 2. Тайлант онд 6,944.1 мянган төгрөгийн үнэ бүхий зөөврийн компьютер, таблет биетээр оршин байхгүй байхад эрх бүхий этгээдэд хандаж шийдвэрлүүлээгүй, төрийн өмчийг үрэгдүүлсэн ажилтнаар хөрөнгийг нөхөн төлүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.1 “анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.5 “эвдэрсэн, гэмтсэн, чанар байдлаа алдсанаас хэрэгцээнд тохиохгүй болсон тухайн үеийн зах зээлийн үнийн жишгээс хэт өндөр үнээр авсан, хэт доогуур үнээр борлуулсан үндсэн хөрөнгө, түүхий эд, бараа материалын үнэ бүхий зүйлийн жагсаалтыг илрүүлж гэм буруутай хүмүүсээр төлүүлэх буюу данснаас хасуулах тухай саналаа тавих” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Жилийн эцсийн өмч хөрөнгийн тооллогоор биетээр оршин байхгүй хөрөнгийг үрэгдүүлсэн ажилтнаар нөхөн төлүүлээгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Тус байгууллага 2022 онд анх байгуулагдахад Насан туршийн боловсролын төвийн балансаас санхүүгийн тайланд нэгтгэгдсэн Голомт банкны дансанд байрших 5.9 мянган төгрөг одоо хүртэл байршиж, арилжааны банкны данс хаагдаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3 "Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр банканд тусдаа данс нээснээс бусад тохиолдолд төсөвт хамаарах бүх гүйлгээг Төрийн сангийн нэгдсэн дансаар гүйцэтгэнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тус байгууллагад ашиглагддаггүй Голомт банкны харилцах дансыг хаах.

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт 2: ТӨБЗГ-ын 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн А-1/2345 дугаартай албан бичгээр Боловсролын мэдээллийн технологийн төвийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 262,591.6 мянган төгрөгийн балансын үнэтэй 1200 ширхэг Microsoft 365 А3, 45,057.8 мянган төгрөгийн балансын үнэтэй 100 ширхэг Microsoft 365 А5 программын эрхийг Боловсролын ерөнхий газарт балансаас балансад шилжүүлсэн байна.

Эрх сунгалттай холбоотой төлбөрийг Сангийн сайдын 2025 оны А/03 тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 11.9 "Программ хангамжтай холбоотой жил тутмын сайжруулалт, ашиглалтын гэрээгээр ашиглаж буй программ хангамжид нэмэлт хөгжүүлэлт хийх, эрх сунгалтын төлбөрийг урсгал засвар, үйлчилгээ гэж үзэн тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрнө" гэж заасан боловч программын эрхийг үндсэн хөрөнгө данснаас хасаж, тайлант үед гарах зардлыг зардлаар хүлээн зөвшөөрөлгүйгээр хорогдуулалт хийж байгаа нь дээрх заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгө дансанд бүртгэлтэй программын эрх сунгалтыг тус данснаас хасаж, цаашид эрх сунгалттай холбоотой төлбөрийг тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэж байх.

Илрүүлэлт 3: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 69 нэр төрлийн 481 ширхэг 617,829.7 мянган төгрөгийн хөрөнгийг ашиглах хугацааг шинэчлэн тогтоох, акталж данс бүртгэлээс хасах, бодит үнэ цэнээр бүртгэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх" журмын 7 дугаар зүйлд "Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийн ашиглах хугацааг шинэчлэн тогтоох, данс бүртгэлээс хасах, бодит үнэ цэнээр бүртгэх асуудлуудыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх

Илрүүлэлт 4: Тус байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 56,771.8 мянган төгрөгийн үнэтэй 80 ширхэг ширээ бүхий зөөврийн хаалт/кабин/ биетээр байхгүй, эрх бүхий байгууллагын шийдвэргүй нийслэлийн ЕБС-д ашиглуулж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.Төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн болон түрээсийн гэрээгээр, мөн хуулиар зөвшөөрсөн бол үнэ төлбөргүйгээр бусдад эзэмшүүлж, ашиглуулж болно гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төрийн өмч, хөрөнгийг бусдад шилжүүлж, ашиглуулахдаа эрх бүхий төрийн байгууллагаас зөвшөөрөл, шийдвэр авч байх

Илрүүлэлт 5: ТӨБЗГ-ын 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 496 дугаар тогтоолоор 318,169.7 мянган төгрөгийн хөрөнгийг акталсан боловч үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайланд 396,496.0 мянган төгрөгөөр тусгаж, 78,326.3 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв" байх, 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн зөрүүг арилгах талаар холбогдох эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлэх.

3. Цалин, урамшуулалтай холбоотой асуудал

Илрүүлэлт 6: Ажил гүйцэтгэх гэрээгээр сургалт зохион байгуулсан цагийн багш нарын ажлын хөлсийг олгохдоо ажил олгогчоос хариуцан төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг суутгадаг боловч нийгмийн даатгалын болон татварын тайланд тусгагдахгүй, зөрүүтэй илэрхийлэгдэх эрсдэл байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4.үнэн зөв байх, 5.1.5.хариуцлагатай байх, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 "Ажил олгогч дараах үүрэг хүлээнэ: 32.2.1.хөдөлмөрийн гэрээ, ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон тэдгээртэй адилтгах гэрээ байгуулсан өдрөөс эхлэн ажилтныг нийгмийн даатгалд албан журмаар даатгуулах, 32.2.2. орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр

ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ажил гүйцэтгэх гэрээгээр сургалт зохион байгуулсан цагийн багш нарын ажлын хөлсийг тооцохдоо холбогдох суутгалыг нийгмийн даатгал болон татварын тайланд үнэн зөв тайлагнах, түүнд тавих хяналтыг сайжруулах.

4. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт 7: Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн цахим контент, дижитал сурах бичгийн цахим систем нэвтрүүлэх хөтөлбөрийн хүрээнд 1-12 дугаар ангийн дижитал сурах бичгийн системийг нийт 8,169,000.0 мянган төгрөгөөр гүйцэтгүүлж байгаа боловч тус системийг санхүүгийн тайланд бүртгэх, ашиглалт, хадгалалт, үр дүнд хяналт тавихтай холбоотой зохицуулалт байхгүй, НБББББ-т нарийвчлан тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт", 5 дугаар зүйлийн 5.1 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4.үнэн зөв байх; 5.1.6.зохицох", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн цахим контент, дижитал сурах бичгийг нягтлан бодох бүртгэлд хэрхэн тусгах, системийн ашиглалт хадгалалт, үр дүнд хяналт хэрэгжүүлэх талаар саналыг дээд шатны байгууллагад хүргүүлэх.

Илрүүлэлт 8: Тайлант онд нийт 4,393,145.3 мянган төгрөгийн номын түрээсийн орлого төвлөрсөн бөгөөд орлогын бүртгэлийг аккруэл сууриар бус мөнгөн сууриар бүртгэж байгаа нь харьяа байгууллагуудын номын түрээсийн орлого бүрэн төвлөрөхгүй, өглөг, авлага үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх, мөн төрийн өмч хөрөнгөнд тавих дотоод хяналт алдагдах эрсдэлтэй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт", 5 дугаар зүйлийн 5.1 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4.үнэн зөв байх; 5.1.6.зохицох", 6 дугаар зүйлийн 6.1. "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө", 20 дугаар зүйлийн 20.2.5. "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Түрээсийн номын сангийн орлогын бүртгэлийг аккруэл сууриар хүлээн зөвшөөрч бүртгэж, хөрөнгийн бүртгэл, тайлагналд тавих хяналтыг сайжруулах

Илрүүлэлт 9: Тайлант онд 3,473,901.0 мянган төгрөгийн сурах бичгийг улсын төсвийн хөрөнгөөр хэвлүүлсэн бөгөөд сурах бичиг хэвлүүлэх, орлогод авах, байгууллагуудад хуваарилж тараах, эргэн хяналт хэрэгжүүлэх зэрэг үйл явцад зохицуулалт байхгүй байна.

Үүнээс шалтгаалан хэвлүүлсэн сурах бичгийг БЕГ-ын санхүүгийн тайланд эргэлтийн хөрөнгийн орлогод авалгүй, зардлаар бүртгэж, харин Түрээсийн сурах бичгийн санхүүгийн тайланд эргэлтийн хөрөнгөөр орлого авч, орлого авахдаа эх үүсвэрийг үйл ажиллагааны бусад орлого гэж бүртгэж байна.

Энэ нь БЕГ-ын санхүүгийн үр дүнгийн тайланд зардал илүү, эргэлтийн хөрөнгийн орлого дутуу, Түрээсийн сурах бичгийн номын санхүүгийн тайланд орлого илүү бүртгэгдэж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт", 5 дугаар зүйлийн 5.1 "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4.үнэн зөв байх; 5.1.6.зохицох" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сурах бичиг хэвлүүлэх, орлого авах, байгууллагуудад хуваарилж тараах, эргэн хяналт хэрэгжүүлэх үйл явцад хяналт тавих зохицуулалтыг тодорхой болгох.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн цахим контент, дижитал сурах бичгийн цахим систем нэвтрүүлэх хөтөлбөрийн хүрээнд 1-12 дугаар ангийн дижитал сурах бичгийн системийг нийт 8,169,000.0 мянган төгрөгөөр гүйцэтгүүлж байгаа боловч тус системийг санхүүгийн тайланд бүртгэх, ашиглалт, хадгалалт, үр дүнд хяналт тавихтай холбоотой зохицуулалт байхгүй, НБББББ-т нарийвчлан тусгаагүй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Тайлант онд нийт 4,393,145.3 мянган төгрөгийн номын түрээсийн орлого төвлөрсөн бөгөөд орлогын бүртгэлийг аккруэл сууриар бус мөнгөн сууриар бүртгэж байгаа нь харьяа байгууллагуудын номын түрээсийн орлого бүрэн төвлөрөхгүй, өглөг, авлага үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх, мөн төрийн өмч хөрөнгөнд тавих дотоод хяналт алдагдах эрсдэлтэй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Тайлант онд 3,473,901.0 мянган төгрөгийн сурах бичгийг улсын төсвийн хөрөнгөөр хэвлүүлсэн бөгөөд сурах бичиг хэвлүүлэх, орлогод авах, байгууллагуудад хуваарилж тараах, эргэн хяналт хэрэгжүүлэх зэрэг үйл явцад зохицуулалт байхгүй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-

Боловсролын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<p>Үүнээс шалтгаалан хэвлүүлсэн сурах бичгийг БЕГ-ын санхүүгийн тайланд эргэлтийн хөрөнгийн орлогод авалгүй, зардлаар бүртгэж, харин Түрээсийн сурах бичгийн санхүүгийн тайланд эргэлтийн хөрөнгөөр орлого авч, орлого авахдаа эх үүсвэрийг үйл ажиллагааны бусад орлого гэж бүртгэж байна.</p> <p>Энэ нь БЕГ-ын санхүүгийн үр дүнгийн тайланд зардал илүү, эргэлтийн хөрөнгийн орлого дутуу, Түрээсийн сурах бичгийн номын санхүүгийн тайланд орлого илүү бүртгэгдэж байна.</p>													
<p>Тус байгууллага 2022 онд анх байгуулагдахад Насан туршийн боловсролын төвийн балансаас санхүүгийн тайланд нэгтгэгдсэн Голомт банкны дансанд байршиж 5.9 мянган төгрөг одоо хүртэл байршиж, арилжааны банкны данс хаагдаагүй байна.</p>	1	5.9	-	-	-	-	1	5.9	-	-	-	-	-
<p>Тайлант онд 6,944.1 мянган төгрөгийн үнэ бүхий зөөврийн компьютер, таблет биетээр оршин байхгүй байхад эрх бүхий этгээдэд хандаж шийдвэрлүүлээгүй, төрийн өмчийг үрэгдүүлсэн ажилтнаар хөрөнгийг нөхөн төлүүлээгүй байна.</p>	1	6,944.1	-	-	1	6,944.1	-	-	-	-	-	-	-
<p>ТӨБЗГ-ын 2022 оны А-1/2345 дугаартай албан бичгээр Боловсролын мэдээллийн технологийн төвийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 262,591.6 мянган төгрөгийн балансын үнэтэй 1200 ширхэг Microsoft 365 А3, 45,057.8 мянган төгрөгийн балансын үнэтэй 100 ширхэг Microsoft 365 А5 программын эрхийг Боловсролын ерөнхий газарт балансаас балансад шилжүүлсэн байна.</p> <p>Эрх сунгалттай холбоотой программын төлбөрийг үндсэн хөрөнгө данснаас хасаж, тайлант үед гарах зардлыг зардлаар хүлээн зөвшөөрөлгүйгээр хорогдуулалт хийж байна.</p>	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	-
<p>Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 69 нэр</p>	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	-

Боловсролын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

төрлийн 481 ширхэг 617,829.7 мянган төгрөгийн хөрөнгийг ашиглах хугацааг шинэчлэн тогтоох, акталж данс бүртгэлээс хасах, бодит үнэ цэнээр бүртгэх асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.													
Тус байгууллагын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 56,771.8 мянган төгрөгийн үнэтэй 80 ширхэг ширээ бүхий зөөврийн хаалт/кабин/ биетээр байхгүй, эрх бүхий байгууллагын шийдвэргүй нийслэлийн ЕБС-д ашиглуулж байна.	1	56,771.8	-	-	-	-	1	56,771.8	-	-	-	-	-
ТӨБЗГ-ын 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 496 дугаар тогтоолоор 318,169.7 мянган төгрөгийн хөрөнгийг акталсан боловч үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайланд 396,496.0 мянган төгрөгөөр тусгаж, 78,326.3 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.	1	78,326.3	-	-	-	-	1	78,326.3	-	-	-	-	-
Байгууллагад төлөх 272,004.1 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	1	272,004.1	-	-	1	272,004.1	-	-	-	-	-	-	-
Ажил гүйцэтгэх гэрээгээр сургалт зохион байгуулсан цагийн багш нарын ажлын хөлсийг олгохдоо ажил олгогчоос хариуцан төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг суутгадаг боловч нийгмийн даатгалын болон татварын тайланд тусгагдахгүй, зөрүүтэй илэрхийлэгдэх эрсдэл байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	-
Дүн	11	414,052.2	-	-	2	278,948.2	9	135,104.0	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих 27 нэр төрлийн 147 мэдээллээс 137 мэдээллийг хугацаанд нь, 8 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна. Нийтэд ил тод мэдээлэх шаардлагатай Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг, Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл гэсэн цонх нээгдээгүй, нээлгэх талаар асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх арга хэмжээ авч ажиллаагүй.	1	-	-	-	-	-	1	-
Дүн	1	-	-	-	-	-	1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой								
Кембрижийн их сургуулийн канцлер, магистр, эрдмийн албанаас 1,350,000.0 мянган төгрөгийн үйлчилгээг нэг эх үүсвэрээр худалдан авахаар төлөвлөгөөнд тусгасан боловч шууд гэрээ байгуулсан байна.	1	-	-	-	1	-	-	-
Олимпиадын ерөнхий хорооны бүрэлдэхүүнийг баталсан тушаал гаргаагүй байна. Үүний улмаас олимпиад зохион байгуулах үйл ажиллагаа эрх зүйн үндэслэлгүй явагдах, хяналт, шийдвэр гаргалт алдагдах эрсдэлтэй байна.	1	-	-	-			1	-
Тус байгууллага нь он дамжин хэрэгжиж буй 2,550,620.0 мянган төгрөгийн төсөл, арга хэмжээг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй, шууд худалдан авалт хийсэн.	1	2,550,620.0	-	-	1	2,550,620.0	-	-
Дүн	3	2,550,620.0	-	-	2	2,550,620.0	1	-
Нийт дүн	4	2,550,620.0	-	-	2	2,550,620.0	2	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 24/А0171245

Улаанбаатар хот

САГ - 2026/41/НА - СТА - ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Боловсролын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагад төлөх 272,004,047.00 /Хоёр зуун далан хоёр сая дөрвөн мянга дөчин долоон/ төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7 "Авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй"-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Байгууллагад төлөх өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Боловсролын ерөнхий газрын дарга /Т.Ням-Очир/, ахлах нягтлан бодогч /С.Бадам/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Г.ОЮУНТӨГӨЛДӨР
Э.БУЛГАНЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 25/A0171245

Улаанбаатар хот

САГ-2026/41/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Боловсролын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллага нь он дамжин хэрэгжиж буй 2,550,620,000.00 /Хоёр тэрбум таван зуун тавин сая зургаан зуун хорин мянган/ төгрөгийн төсөл, арга хэмжээг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй, шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-д "захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/250 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2 дугаар зүйлийн 2.2-т "захиалагч төлөвлөгөөг батлагдсан нийт төсөвт үндэслэн төсөл, арга хэмжээ нэг бүрээр энэ журмын хавсралтын 1 дүгээр маягтын дагуу цахим системд боловсруулна." 3-т "тухайн жилийн төсөвт он дамжин хэрэгжихээр тусгагдсан төсөл, арга хэмжээг төлөвлөгөөнд тусгаж, тайлбарт он дамжин хэрэгжиж байгаа талаар дурдана" гэж тус тус заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол"-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсөл, арга хэмжээг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгалгүй, шууд худалдан авалт хийж байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Боловсролын ерөнхий газрын дарга /Т.Ням-Очир/, ахлах нягтлан бодогч /С.Бадам/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Г.ОЮУНТӨГӨЛДӨР
Э.БУЛГАНЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-261230

9025081411

Z:\Alban Shaardlaga\2026\0123 SAC-4.Docx

1526180045



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 26/A0171245

Улаанбаатар хот

САГ-2026/41/КА - СТА - ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Боловсролын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Кембрижийн их сургуулийн канцлер, магистр, эрдмийн албанаас 1,350,000,000.00 /Нэг тэрбум гурван зуун тавин сая/ төгрөгийн үйлчилгээг нэг эх үүсвэрээр худалдан авахаар төлөвлөгөөнд тусгасан боловч шууд гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1-д "Захиалагч дараах нөхцөлд нэг эх үүсвэрээс худалдан авах аргыг хэрэглэж болно: 36.1.1 оюуны өмчийн эрхийг хамгаалах шаардлагаар бараа, ажил, үйлчилгээг үйлдвэрлэгч оюуны өмчийн эрх эзэмшигч, эсхүл түүнээс лицензийн гэрээний дагуу ашиглах эрх авсан албан ёсны нэг этгээд гүйцэтгэх боломжтой бол", 41.1-д "Худалдан авах гэрээ дараах нөхцөлийн аль нэгд хамаарах бол илт хууль бус байна: 41.1.1 энэ хуулийг зөрчиж гэрээ шууд байгуулсан", Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/250 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2.2-т "Захиалагч төлөвлөгөөг батлагдсан нийт төсөвт үндэслэн төсөл, арга хэмжээ нэг бүрээр энэ журмын хавсралтын 1 дүгээр маягтын дагуу цахим системд боловсруулна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9 "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол"-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан арга, хэлбэрээр худалдан авах ажиллагааг зохион байгуулахгүй байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Боловсролын ерөнхий газрын дарга /Т.Ням-Очир/, ахлах нягтлан бодогч /С.Бадам/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Handwritten signature



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Г.ОЮУНТӨГӨЛДӨР
Э.БУЛГАНЧИМЭГ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 27/A0171245

Улаанбаатар хот

САГ-2026/41/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Боловсролын ерөнхий газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 6,944,080.00 /Зургаан сая есөн зуун дөчин дөрвөн мянга наян/ төгрөгийн үнэ бүхий зөөврийн компьютер, таблет биетээр оршин байхгүй байхад эрх бүхий этгээдэд хандаж шийдвэрлүүлээгүй, төрийн өмчийг үрэгдүүлсэн ажилтнаар хөрөнгийг нөхөн төлүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 13 дугаар зүйлийн 13.1-т “анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.5-д “эвдэрсэн, гэмтсэн, чанар байдлаа алдсанаас хэрэгцээнд тохиохгүй болсон тухайн үеийн зах зээлийн үнийн жишгээс хэт өндөр үнээр авсан, хэт доогуур үнээр борлуулсан үндсэн хөрөнгө, түүхий эд, бараа материалын үнэ бүхий зүйлийн жагсаалтыг илрүүлж гэм буруутай хүмүүсээр төлүүлэх буюу данснаас хасуулах тухай саналаа тавих” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.1 “нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй”-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Жилийн эцсийн өмч хөрөнгийн тооллогоор биетээр оршин байхгүй хөрөнгийг эрх бүхий этгээдэд хандаж шийдвэрлүүлээгүй, төрийн өмчийг үрэгдүүлсэн ажилтнаар хөрөнгийг нөхөн төлүүлээгүй зөрчлийг арилгаж, Биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Боловсролын ерөнхий газрын дарга /Т.Ням-Очир/, ахлах нягтлан бодогч /С.Бадам/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Г.ОЮУНТӨГӨЛДӨР
Э.БУЛГАНЧИМЭГ

Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-204230

Z:\Alban Shaardlaga\2026\0123 SAG-4.Docx

1526180079